

БНСУ-ЫН ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ТАЛААРХ БОДЛОГО БА ТҮҮНИЙ ЧИГ ХАНДЛАГА

Л. Долгормаа¹

1990-ээд оны дундаас эхэлсэн БНСУ-д хөдөлмөр эрхлэх зорилгоор зорчих болсон монгол иргэдийн тоо сүүлийн 10-аад жилийн дотор эрс нэмэгдэж өнөөдөр энэ улсад ажиллаж буй манай иргэдийн ар гэртээ илгээж буй мөнгө дотоодын эдийн засаг, иргэдийн амьжиргаанд тодорхой хэмжээнд нөлөөлөх болжээ.

Монгол хүн Монгол улсын нөөц баялаг гэж хэдий хэлдэг, ярьдаг хэдий ч өнгөрсөн хугацаанд барагцаалбал 50 гаруй мянган иргэдээ Солонгос руу илгээхдээ тодорхой бодлогогүй, хэтийн хандлагагүйгээр илгээж байсан гэхэд болох юм. Монгол хүний орлогын доод хэмжээ таван зуун мянган төгрөгөөс дээш болоогүй цагт Солонгосыг чиглэсэн энэхүү хөдөлмөрийн хүчний урсгал тасрахгүй бас татрахгүй нь ойлгомжтой юм. Тэгвэл энэхүү үнэт капитал аа гадны оронд илгээхдээ буцаад эх орондоо хэрэгтэй, дотоодын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэн болгож авах, нөгөө талаар эдгээр иргэдийг эх орондоо ирээд дасан суурьшихад төрөөс дэмжиж туслах үүднээс БНСУ-ын гадаадын хөдөлмөрийн цагаач иргэдийн талаарх бодлогыг судалж, тэдний эрэлт хэрэгцээг өөрсдийн хөдөлмөрийн хүчний бодлоготой уялдуулах нь зүйтэй билээ. Нөгөө талаар Монгол улсын үе үеийн ерөнхийлөгч, ерөнхий сайд нар БНСУ-ын төр засгийн удирдлагуудтай уулзах үеэрээ тус улсад зорчиж буй монгол иргэдэд визний хөнгөлөлттэй нөхцөл олгох, хөдөлмөр эрхэлж буй монгол иргэдэд хатуурхахгүй байхыг уулзалтын гол асуудлаа болгон тавьдаг. Харин БНСУ-ын Хууль зүйн яам, Хөдөлмөрийн яамнаас гаргасан дүгнэлтээр бол монгол иргэдэд ийм боломж нөхцлийг олгох боломжгүй шалтгаан нь тэдний багагүй хувь нь хууль бусаар хөдөлмөр эрхлэхээр үлддэгт байдаг байна. Олон монгол хүн Солонгост хууль бусаар хөдөлмөр эрхэлж байгаа нь энэ асуудлыг хувь хүний асуудал мэтээр орхиж, тодорхой бодлого, бэлтгэлгүй байгаад оршиж байгаа юм. Энэхүү судалгаагаар 2000 оноос хойш хөдөлмөр эрхлэгч гадаадын цагаач иргэдийн талаар авч буй БНСУ-ын төрийн бодлого, хэтийн хандлагыг тандаж, түүнд дүйцүүлэн Монгол улс ажиллах хүч гадаадад гаргахдаа эргээд дотоодын эдийн засагт ашигтай, гадаадад ажиллаад ирсэн хувь хүнд хэрэгтэй ямар бодлого, чиг хандлага байж болохыг дэвшүүлэхийг зорьлоо.

1. БНСУ-ын төрөөс авч хэрэгжүүлж буй хөдөлмөрийн цагаачлалын талаарх бодлого

1998 оны валютын хямралаас өмнө Солонгос улс хөдөлмөр эрхэлдэг гадаад иргэдэд хатуурхдаггүй байв. Харин 2000 оноос хойш тэдний тоо 400 мянгыг хол давж, 2008 он гэхэд нийт хөдөлмөр эрхлэгч гадаад иргэдийн тоо 700 мянгад хүрч тэр хэмжээгээр хууль бусаар оршин суугчдын тоо нэмэгдэн, нийгэмд сөрөг үр дагавар нь илтэд мэдрэгдэх болсон байна. Хөдөлмөрийн насны хүн амын дундаж нас өндөрсөж, иргэдийн боловсролын дундаж түвшин дээшилсэн, залуучууд хүнд хүчир ажлаас зайлсхийх болсон зэрэг олон үзэгдлүүд нөлөөлж Солонгосын хөдөлмөрийн зах зээл дээр гадны хямд ажиллах хүчийг авах сонирхол улам

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш

бүр нэмэгдэж байгаа тул засгийн газар нь энэ тал дээр чанарын өөрчлөлт бүхий бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн юм. Гадаадаас ажиллах хүч авч эхэлснээс хойшх хамгийн тулгамдсан асуудал бол гадаад иргэдийн тоо нэмэгдэхийн хэрээр хууль бусаар хөдөлмөр эрхлэгчдийн тоо нэмэгдэж байгаа явдал юм. Ийм учраас нийгмийн аюулгүй байдал, дотоодын хөдөлмөрийн зах зээлийн аюулгүй байдлыг хангахын тулд БНСУ-ын засгийн газраас “Ажил олгох зөвшөөрлийн тогтолцоо”-нд үндэслэн гадаадаас хөдөлмөрийн дадлага туршлага бүхий бэлтгэгдсэн ажиллах хүчнийг олноор оруулж ирэх, хууль бусаар оршин сууж гадаад иргэдийг нэн даруй буцаах арга хэмжээг эрчимтэй өрнүүлж байна.

2005 оноос өмнө хэрэгжүүлж байсан “Үйлдвэрлэлийн дадлагажигчийн тогтолцоо” нь хэт уян хатан бус, ажил олгогчдын эрэлт хэрэгцээг харгалзаагүй зэрэг сул талуудтай байсан бол “Ажил олгох зөвшөөрлийн тогтолцоо” нь хууль ёсны зөвшөөрлийн дагуу ирж хөдөлмөрлөж байгаа гадаадын иргэдийн нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулахыг хуулиар баталгаажуулж, ажлын байрны уян хатан нөхцлийг хангасан зэрэг олон давуу талтай юм.

Өнөөдөр уг тогтолцоогоор дамжуулан БНСУ-д ажиллах хүч гаргах зөвшөөрөл бүхий орнуудад Филиппин, Тайланд, Вьетнам, Шриланка, Монгол, Индонез, Узбекистан, Пакистан, Кампучи, Хятад, Бангладеш, Балба, Мьянмар, Киргиз, Зүүн Тимур багтаж байна. 2008 оны сүүлийн байдлаар үзэхэд БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа нийт 694,862 гадаадын иргэн байгаагийн дотор 477,8219 нь хууль ёсны дагуу, 202,520 нь хууль бусаар хөдөлмөр эрхэлж байгаа юм.

Хүснэгт 1. БНСУ-ын гадаадаас авсан ажиллах хүчний тоон үзүүлэлт

Төрөл	2004	2005	2006	2007
Ажил олгох зөвшөөрлийн тогтолцоо	25,000	38,000	35,250	49,600
Тусгай зөвшөөрөлийн тогтолцоо	16,000	38,000	38,050	60,000
Үйлдвэрлэлийн дадлагажигч	38,000	40,000	31,700	-
Нийт	79,000	116,000	105,000	109,600

Хүснэгт 2. 2008 онд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаад иргэдийн тоо

Улсын нэр	Нийт	Үйлдвэрлэл	Барилга	Хөдөө аж ахуй	Далайн аж ахуй	Хөргөлт хөлдөөх үйлдвэрлэл
Вьетнам	21629	18635	1089	1833	72	0
Индонез	13466	12688	0	33	745	0
Филлипин	8123	7864	198	61	0	0
Тайланд	9999	6174	1738	1073	14	0
Шриланк	8160	8005	1	137	10	1
Монгол	5205	3896	388	484	386	51
Бусад орон	18413	17292	346	1354	399	0
Нийт	84995	74533	3760	4975	1626	52

2. БНСУ-ын гадаадаас ажиллах хүч авах бодлогын хэтийн чиг хандлага

Солонгосын засгийн газраас одоо авч хэрэгжүүлж буй “Ажил олгох зөвшөөрлийн тогтолцоо”-ны өөр нэг онцлог бол ажил олгогчдын эрэлт хэрэгцээн дээр тулгуурлаж, хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулдаг, нийт ажилчдын тоо нь 50-иас багагүй аж ахуйн нэгжүүдийн хүсэлт дээр үндэслэн гадаадаас ажиллах хүч оруулдаг тул урьд өмнө нь гарч байсан компани нь дампуурч гадаадын иргэн ажилгүй болох, ажил олгогчид хариуцлагаа хүлээхгүй сураггүй болох зэрэг асуудлууд харьцангуй хумигдсан байна. Энэ тогтолцоог хэрэгжүүлж эхэлснээс хойшхи 3 жил гаруйн хугацааны үр дүнг дүгнэж үзэхэд гадаадын иргэдийг авч ажиллуулахад өндөр зардалтай тусдаг, мэргэжлийн чадваргүй хүмүүсийг илгээдэг гэсэн шүүмжлэлийг ажил олгогчид гаргажээ. Тиймээс БНСУ-ын Хөдөлмөрийн яам нь цаашид гадаадаас ажиллах хүч авахдаа зөвхөн дан ганц солонгос хэлний чадварыг харгалзах бус ажлын туршлага, мэргэжлийн ур чадварыг тодорхой шалгуур болгон оруулахаар болсон байна. БНСУ-ын Хөдөлмөрийн яамнаас гаргасан “2009 онд гадаадаас ажиллах хүч авах төлөвлөгөө”²-нөөс үзвэл ажиллах хүч илтэд дутагдаж буй үйлдвэрлэл, хөдөө аж ахуй зэрэг салбарт цаашид гадаадаас авах ажиллах хүчний тоог нэмэгдүүлж, барилга, үйлчилгээний салбарт Хятад, ОХУ-д амьдарч буй солонгос үндэстнийг түлхүү хамруулан ажиллуулах чигийг баримтлахаар болжээ.

Хүснэгт 3. Салбар тус бүрээр хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэний тоо /2008 он/

	Салбар	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
1	Үйлдвэрлэл	141839	127449	14390
2	Барилга	8846	8843	3
3	Хөдөө аж ахуй	4748	3756	992
4	Далайн аж ахуй	1759	1747	12
5	Хөргөлт, хөлдөөх үйлдвэрлэл	101	100	1
6	Нийтийн хоолны үйлчилгээ	555	102	453

3. Монгол улсын гадаад ажиллах хүч илгээх бодлогын өнөөгийн байдал

Манай улс гадаадад ажиллах хүч илгээхээр Япон улстай 1994 онд Хамтран ажиллах протокол, 1999 онд Чех улстай Хамтын ажиллагааны гэрээ, Тайвантай 2001 онд “Тайван руу ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичиг”, 2005 онд БНСУ-тай “БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичиг” тус тус байгуулж байжээ. Өнөөдөр эдгээр гэрээ, санамж бичгийн дагуу БНСУ-д 12735³, Чех-д 4000, Японд 1000 гаруй монгол хүн ажиллаж байгаа баримжаа тоо байна. Манай улсын иргэд хамгийн олноор амьдарч, ажиллаж байгаа орон бол яах аргагүй Өмнөд Солонгос улс бөгөөд өнөөгийн байдлаар нийт тэнд оршин сууж буй 32206 монгол иргэний 13672 нь хууль бусаар оршин сууж байна. 2004 оны үед хорин мянга давж байсан энэ үзүүлэлт эрчимтэй буурснаас үзвэл Солонгосын засгийн газраас гадаадын иргэдийг хууль ёсны зөвшөөрөлтэйгөөр тодорхой хязгаарлагдмал салбарт авч ажиллуулах бодлогыг бодитойгоор хэрэгжүүлж байгааг харж болно. 2008 оны байдлаар хууль бусаар оршин сууж буй монгол иргэдийн 4431 буюу 30 хувь нь БНСУ-д

² БНСУ-ын Хөдөлмөрийн яам, “2009 онд гадаадаас ажиллах хүч авах төлөвлөгөө”, www.molab.go.kr

³ Ministry of Justice, ROK, Korea Immigration Service Statistics 2008.

хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэйгээр очоод “харласан” буюу хөдөлмөрлөхөөр зөвшөөрөл авсан ажлын байрнаасаа зугтсан иргэд байгаа юм. Энэхүү өндөр үзүүлэлт нь хэдий хууль ёсны боловч гадаадад ажиллахаар явахдаа тэндэх хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны онцлог, хууль ёсны дагуу ажиллаж амьдарснаар ямар давуу тал эдэлдэг талаар хангалттай мэдээлэл байхгүй байсныг харуулж байна. Нөгөө талаар Солонгост гэрээгээр ажиллаж буй монгол иргэний цалин адил нөхцлөөр ажиллаж буй гадаадын иргэдийн дундаж цалингаас даруй 150 ам.доллараар доогуур байгаа нь энэ нөхцлийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгааг харуулж байна. Тиймээс цаашид БНСУ руу ажиллах хүч илгээхээсээ өмнө тодорхой хэмжээнд мэргэжлийн дадлага, сургалтад хамруулах нь олон талаар ач холбогдолтой юм. Нэгдүгээрт, мэргэжлийн түр сургалтад хамрагдсанаар санал болгосон ажлын байранд дасан зохицох сэтгэл зүйн бэлтгэлтэй болж тогтвортой ажиллах болно. Энэ нь хууль бусаар хөдөлмөр эрхлэх явдлыг бууруулж, улмаар БНСУ-аас Монгол улсад олгож буй ажиллах хүчний квотыг тогтвортойгоор өсгөх, манай улсын иргэд БНСУ руу зорчих визийн нөхцлийг хөнгөвчлөхөд үндсэн нөхцлийг бүрдүүлж өгөх юм.

Мөн түүнчлэн үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, хөргөөх хөлдөөх үйлдвэрлэл, барилга, үйлчилгээний салбарт гэрээгээр ажиллахаар явж байгаа болон ажиллаад ирсэн иргэддээ тухайн салбарт бизнес эрхлэх хөнгөлөлттэй нөхцлийг олгох, холбогдох ажлын байранд нь зуучлах ажиллагааг цогц уялдаа холбоотойгоор төрөөс зохион байгуулах нь маш чухал байна. Хэдий тодорхой судалгаа байхгүй боловч Солонгост ажиллаад ирсэн олон мянган залуус өнөөдөр ажлын байргүй, буцаад явах сонирхолтой байгаа нь бодит үнэн бөгөөд энэ нь тэдний ганц нэгд бус дийлэнх олонхид нь тулгарч буй асуудал тул хувь хүний асуудал хэмээн орхиж болохгүй билээ. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, зээл, эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх чиглэлээр олгож байгаа бизнесийн хөнгөлөлттэй зээл, техникийн туслалцаа зэрэг хөтөлбөрүүдэд БНСУ-д эрчимжсэн мал ахуйн ферм, хүлэмжийн аж ахуй, барилга, хөнгөн болон хүнд үйлдвэр, хүнд механизмын засвар үйлчилгээний чиглэлээр ажиллаад ирсэн хүмүүсийн дадлага туршлагыг харгалзан хамруулах асуудлыг дэмжиж, мэдээллээр хангах асуудлыг оновчтойгоор шийдэх нь эргээд гадаадад ажиллаад ирсэн хүмүүсийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажилгүйдлийг бууруулах, эдийн засгийг эрчимжүүлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт технологи, ур чадварыг нэмэгдүүлэх зэрэг олон давуу талтай юм.

Ашигласан материал

1. НХХЯ, “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны 2008 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан”, 2008
2. ADB, “Asian Development Outlook”, 2005
3. Ministry of Justice, ROK. “Korea Immigration Service Statistics 2008 year”, 2008
4. UNDP, “MDG National Report 2004”, page. 9., 2004
5. 노동부, “2009년 외국인력 도입계획”, 2009
6. 이규용. 이태정., “외국인 불법체류 및 취업문제, 어떻게 바라볼 것인가?”, 노동리뷰, 2007
7. 이규용. “외국인인력정책 변화와 과제”, 노동리뷰, 2007
8. 이규용. 박성재., “외국인력 고용구조와 영향”, 노동리뷰, 2008
9. 한국기술교육대학교, “외국인고용허가제시행 3주년 평가 및 제도개선방안 연구”, 2007